

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 он

ГХБХБГазар

Хамрагдах хугацаа:

2023.01.05-2023.05.15

Судалгаанд оролцогчдын тоо:

850

Судалгааны хэлбэр:

тус газраас газартай холбоотой үйлчилгээг авч буй иргэдээс үйлчилгээний хүртээмж болон үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн байдалд заавал бөглөх байдлаар авсан.

Санал асуулга:




Асуулт 1: Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээнд та хэр сэтгэл ханамжтай байна вэ ?

Нийт санал асуулгад оролцогчдын 89 хувь нь буюу 756 үйлчлүүлэгч тийм гэсэн хариултыг өгсөн.



Асуулт 2: Таны бодлоор цаашид юуг анхаарах шаардлагатай байна вэ ?

Нийт санал асуулгад оролцогчдын 59 хувь нь буюу 476 үйлчлүүлэгч хууль эрхзүйн орчинг боловсронгуй болгох гэсэн бол 35 хувь буюу 298 нь асуудал шийдвэрлэх шат дамжлагыг багасгах гэсэн хариултыг өгсөн.



Асуулт 3: Та сумынхаа газар зохион байгуулалтын төлөвлөгөөний талаар хангалттай мэдээлэл авч чаддаг уу ?

Нийт санал асуулгад оролцогчдын 62 хувь нь буюу 527 үйлчлүүлэгч тийм гэсэн бол 38 хувь буюу 323 нь үгүй гэсэн хариултыг өгсөн.




Асуулт 4: Та газрын харилцааны талаар ямар үйлчилгээ авч байсан бэ ?

Нийт санал асуулгад оролцогчдын 62 хувь нь буюу 527 үйлчлүүлэгч газар өмчилж авах асуудлаар, 30 хувь буюу 255 нь хэмжилт зураглал, 8 хувь буюу 68 нь лавлагаа мэдээлэл гэсэн хариултыг өгсөн.




Асуулт 5: Та дээрх үйлчилгээг авахын тулд бүрдүүлэх баримт, материалын тухай мэдээллийг хаанаас авсан бэ ?

Нийт санал асуулгад оролцогчдын 90% буюу 765 үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлж байсан ажилтнаас, 7% буюу 59 үйлчлүүлэгч байгууллагын мэдээллийн самбар, тараах материалаас, 26 үйлчлүүлэгч буюу 3% хэвлэл мэдээллийн хэрэгслээс авсан байна.




Асуулт 6: Таны асуудлыг ямар хугацаанд шийдвэрлэсэн бэ ?

Нийт санал асуулгад оролцогчдын 80% нь буюу 680 үйлчлүүлэгч өдөрт нь гэсэн хариултыг өгсөн бол 18% буюу 153 үйлчилүүлэгч 30 хоног дотор, 2% нь буюу 17 үйлчлүүлэгч 30 дээш хоногт гэсэн хариултыг өгсөн.



Асуулт 7: Газрын харилцааны талаар нэг асуудлыг шийдвэрлүүлэхэд хэдэн удаа ирж үйлчлүүлсэн бэ ?

Нийт санал асуулгад оролцогчдын 85 хувь нь буюу 723 үйлчлүүлэгч 1-2 удаа, 12 хувь буюу 102 үйлчлүүлэгч 3-5 удаа, 3 хувь буюу 26 үйлчлүүлэгч 5 дээш удаа гэж үнэлсэн байна.



Асуулт 8: Газрын харилцааны үйл ажиллагааны талаарх мэдээлэл олж авах боломж хэр зэрэг байдаг гэж та үзэж байна вэ ?

Нийт санал асуулгад оролцогчдын 53 хувь нь буюу 450 сайн, 30 хувь буюу 255 үйлчлүүлэгч дунд, 17 хувь буюу 145 үзүүлсэн ажилтан муу гэсэн хариултыг өгсөн.